



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ\*

2019 оны 10 дугаар сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7%-иар буюу 773 сая ам.доллараар өсч 11,593 сая ам.доллар байв. Үүнд экспорт 10%-иар буюу 584 сая ам.доллараар, импорт 4%-иар буюу 189 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 395 сая ам.доллараар өсч 1,464 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 10 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Эргэлт</b>	<b>8,274</b>	<b>10,536</b>	<b>12,887</b>	<b>2,262</b>	<b>27%</b>	<b>2,351</b>	<b>22%</b>	<b>8,719</b>	<b>10,820</b>	<b>11,593</b>	<b>2,101</b>	<b>24%</b>	<b>773</b>	<b>7%</b>
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	5,189	5,945	6,529	756	15%	584	10%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	3,530	4,876	5,065	1,345	38%	189	4%
<b>Тэнцэл</b>	<b>1,558</b>	<b>1,865</b>	<b>1,137</b>	<b>307</b>		<b>(728)</b>	<b>-39%</b>	<b>1,659</b>	<b>1,069</b>	<b>1,464</b>	<b>(589)</b>	<b>-36%</b>	<b>395</b>	<b>37%</b>

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл\*\*** 2019 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 180 сая ам.доллараар өсч 1,547 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65% буюу 7,514 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 1,446 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 1.3%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 5%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 2019 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3%-иар, өмнөх сараас 10%-иар буурч 1.754-д хүрлээ. Худалдааны нөхцлийн индекс өмнөх сараас муудахад зэсийн болон чулуун нүүрсний үнэ өмнөх сарын түвшинд байсан болон ноолуурын экспортын үнийн бууралт голлон тайлбарлаж байна.

\*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

\*\* Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

**Экспорт 2019 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар буюу 584 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 10 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.2 нэгж хувиар тус тус өссөн байна.**

**Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	
<b>1. Уул уурхай</b>		<b>4,592</b>	<b>88%</b>		<b>5,267</b>	<b>89%</b>		<b>5,810</b>	<b>89%</b>		<b>675</b>	<b>15%</b>	<b>13%</b>	<b>543</b>	<b>10%</b>	<b>9%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,204	1,302	25%	1,205	1,669	28%	1,174	1,541	24%	367	28%	7%	(128)	-8%	-2%	
1.2. Чулуун нүүрс	28,143	1,911	37%	30,941	2,439	41%	32,334	2,748	42%	528	28%	10%	309	13%	5%	
1.3. Боловсруулаагүй нефть	6,308	306	6%	4,968	327	5%	5,428	303	5%	20	7%	0%	(24)	-7%	0%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5,030	261	5%	6,048	274	5%	6,699	459	7%	14	5%	0%	185	67%	3%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	12,589	515	10%	3,432	144	2%	7,464	344	5%	(370)	-72%	-7%	200	138%	3%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	101	151	3%	103	167	3%	109	156	2%	16	11%	0%	(12)	-7%	0%	
1.7. Жонош, лейцит, нефелинт	245	63	1%	422	141	2%	558	170	3%	77	122%	1%	30	21%	1%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	32	1%	5	40	1%	5	42	1%	9	27%	0%	1	4%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	7	0%	1	6	0%	1	5	0%	(1)	-8%	0%	(1)	0%	0%	
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	1	0%	0	-	0%	(0)	0%	0%	(1)	0%	0%	
1.11. Бусад	307	44	1%	434	58	1%	128	42	1%	15	34%	0%	(17)	-28%	0%	
<b>2. Мал аж, ахуй</b>		<b>291</b>	<b>33%</b>		<b>420</b>	<b>7%</b>		<b>265</b>	<b>4%</b>		<b>83</b>	<b>25%</b>	<b>2%</b>	<b>4</b>	<b>1%</b>	<b>0%</b>
2.1. Амьд мал, малын мах	19	36	1%	26	59	1%	21	45	1%	23	63%	0%	(14)	-25%	0%	
2.2. Арьс, шир	248	19	0%	275	13	0%	219	12	0%	(5)	-28%	0%	(1)	-9%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	7	0%	0	7	0%	2	35%	0%	(0)	0%	0%	
2.4. Ноолуур	7	251	5%	8	313	5%	8	336	5%	61	24%	1%	23	7%	0%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	15	23	0%	13	25	0%	13	22	0%	2	8%	0%	(2)	-9%	0%	
2.6. Бусад	1	2	0%	3	3	0%	3	2	0%	1	34%	0%	(1)	-22%	0%	
<b>3. Газар тариалан</b>		<b>148</b>	<b>12%</b>		<b>34</b>	<b>0%</b>		<b>38</b>	<b>0%</b>		<b>(4)</b>	<b>-3%</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>17%</b>	<b>0%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>		<b>350</b>	<b>24%</b>		<b>191</b>	<b>2%</b>		<b>330</b>	<b>4%</b>		<b>2</b>	<b>1%</b>	<b>0%</b>	<b>35</b>	<b>14%</b>	<b>1%</b>
4.1. Хүнс	16	68	1%	20	57	1%	17	42	1%	(1)	-16%	0%	(15)	-28%	0%	
4.2. Ноолууран эдлэл	1	27	1%	1	30	1%	1	37	1%	3	11%	0%	7	23%	0%	
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	2	13	0%	3	21	0%	3	16	0%	8	63%	0%	(5)	-24%	0%	
4.4. Уул уурхай	30	91	2%	46	90	2%	141	93	1%	(1)	-1%	0%	2	3%	0%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	3	0%	0	1	0%	2	215%	0%	(2)	-69%	0%	
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	42	1%	3	45	1%	2	91	1%	3	6%	0%	46	102%	1%	
4.7. Бусад	300	6	0%	118	4	0%	167	6	0%	(2)	-29%	0%	2	40%	0%	
<b>5. Бусад</b>		<b>1</b>	<b>0%</b>		<b>1</b>	<b>0%</b>		<b>1</b>	<b>0%</b>		<b>0</b>	<b>8%</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-2%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>5,189</b>		<b>5,945</b>			<b>6,529</b>			<b>756</b>	<b>15%</b>		<b>584</b>	<b>10%</b>		

<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 10 сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>283</b>		<b>261</b>		<b>543</b>	<b>10%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(40)	31%	(88)	69%	(128)	-8%
1.2. Чулуун нүүрс	118	38%	191	62%	309	13%
1.3. Боловсруулаагүй нефть	26	-108%	(49)	208%	(24)	-7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	45		140		185	67%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	186	93%	14	7%	200	138%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	9	-75%	(21)	175%	(12)	-7%
1.7. Жонош, лейцит, нефелинт	42	139%	(12)	-39%	30	21%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(1)	-92%	3	192%	1	4%
1.11. Бусад	(101)	609%	84	-509%	(17)	-28%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>(40)</b>		<b>44</b>		<b>4</b>	<b>1%</b>
2.1. Амьд мал, малын мах	(11)	77%	(3)	23%	(14)	-25%
2.2. Арьс, шир	(3)	251%	2	-151%	(1)	-9%
2.3. Малын өлөн гэдэс	(0)	151%	0	-51%	(0)	0%
2.4. Ноолуур	(25)	-111%	48	211%	23	7%
<b>3. Газар тариалан</b>	<b>1</b>		<b>0</b>		<b>1</b>	<b>17%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>(4)</b>		<b>39</b>		<b>35</b>	<b>14%</b>
<b>5. Бусад</b>	<b>0</b>		<b>(0)</b>		<b>(0)</b>	<b>-2%</b>
<b>Нийт дүн</b>	<b>240</b>		<b>344</b>		<b>584</b>	<b>10%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм

2019 оны эхний 10 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 240 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 344 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 78 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 103 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалж 4 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 39 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 10 дугаар сард 1,495 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 23%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 0.9%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,757; 89 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 7%-иар буурсан бол төмрийн хүдэр 21%-иар өссөн, зэсийн үнэ өмнөх сарын түвшинд хадгалагдаж, төмрийн хүдэр өмнөх сараас 5%-иар буурлаа. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 10 дугаар сард 84 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 5%-иар, өмнөх сараас 3%-иар өслөө.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



**Импорт** 2019 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буюу 189 сая ам.доллараар өсөв. Импортын 4 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 1 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 1 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 4.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>1,050</b>	<b>30%</b>		<b>1,340</b>	<b>27%</b>		<b>1,367</b>	<b>27%</b>	<b>291</b>	<b>28%</b>	<b>8%</b>	<b>27</b>	<b>2%</b>	<b>1%</b>
Түргэн эдлэгтэй	697	594	17%	805	705	14%	743	699	14%	112	19%	3%	(6)	-1%	0%
Хүнс	316	412	12%	383	488	10%	352	489	10%	76	19%	2%	1	0%	0%
Эм, тариа	2	77	2%	2	98	2%	3	89	2%	20	26%	1%	(9)	-9%	0%
Бусад турзан эдлэгтэй бараа	378	105	3%	419	120	2%	388	121	2%	15	14%	0%	1	1%	0%
Удаан эдлэгтэй	179	456	13%	197	635	13%	268	668	13%	179	39%	5%	33	5%	1%
Гутал, хувцас, цүнх	58	51	1%	49	61	1%	55	57	1%	10	19%	0%	(3)	-6%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	66	73	2%	80	95	2%	144	89	2%	21	29%	1%	(6)	-6%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	277	8%	1	411	8%	1	452	9%	134	48%	4%	41	10%	1%
Бусад удаан эдлэгтэй бараа	54	55	2%	67	69	1%	68	70	1%	14	26%	0%	2	3%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>927</b>	<b>1,358</b>	<b>38%</b>	<b>1,236</b>	<b>2,015</b>	<b>41%</b>	<b>1,087</b>	<b>2,186</b>	<b>43%</b>	<b>657</b>	<b>48%</b>	<b>19%</b>	<b>171</b>	<b>8%</b>	<b>4%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	22	846	24%	27	1,263	26%	23	1,439	28%	47	49%	12%	177	14%	4%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	247	7%	1	378	8%	2	502	10%	131	53%	4%	124	33%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	22	599	17%	26	884	18%	21	938	19%	286	48%	8%	53	6%	1%
Барилгын материал	542	370	10%	691	572	12%	868	572	11%	202	55%	6%	1	0%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	52	142	4%	37	180	4%	38	174	3%	38	27%	1%	(6)	-3%	0%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>1,171</b>	<b>454</b>	<b>13%</b>	<b>1,306</b>	<b>608</b>	<b>12%</b>	<b>1,502</b>	<b>562</b>	<b>11%</b>	<b>155</b>	<b>34%</b>	<b>4%</b>	<b>(46)</b>	<b>-8%</b>	<b>-1%</b>
Хүнсний орц	35	16	0%	273	75	2%	44	20	0%	59	358%	2%	(55)	-73%	-1%
Химийн бүтээгдэхүүн	155	89	3%	167	101	2%	188	101	2%	12	13%	0%	(0)	0%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	38	18	1%	66	25	1%	66	24	0%	7	37%	0%	(1)	-6%	0%
Цахилгаан эрчим хүч	2	111	3%	1	118	2%	1	120	2%	7	6%	0%	1	1%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	0	1	0%	1	1	0%	(0)	-7%	0%	0	16%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	695	218	6%	729	289	6%	787	297	6%	71	33%	2%	8	3%	0%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>1,171</b>	<b>663</b>	<b>19%</b>	<b>1,306</b>	<b>906</b>	<b>19%</b>	<b>1,502</b>	<b>945</b>	<b>19%</b>	<b>243</b>	<b>37%</b>	<b>7%</b>	<b>39</b>	<b>4%</b>	<b>1%</b>
Дизель түлш	676	351	10%	694	460	9%	891	549	11%	109	31%	3%	89	19%	2%
АИ-92, АИ-95	313	185	5%	297	211	4%	376	227	4%	26	14%	1%	16	8%	0%
А-80 болон бусад	183	128	4%	314	236	5%	235	169	3%	108	84%	3%	(67)	-28%	-1%
<b>Бусад</b>	<b>13</b>	<b>6</b>	<b>0%</b>	<b>14</b>	<b>6</b>	<b>0%</b>	<b>184</b>	<b>5</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-6%</b>	<b>0%</b>	<b>(1)</b>	<b>-16%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>3,530</b>		<b>4,876</b>			<b>5,065</b>			<b>1,345</b>	<b>38%</b>		<b>189</b>	<b>4%</b>	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 5.** Импортын өөрчлөлт, 2019 он эхний 10 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>(16)</b>	<b>-59%</b>	<b>42</b>	<b>159%</b>	<b>27</b>	<b>2%</b>
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>125</b>	<b>73%</b>	<b>46</b>	<b>27%</b>	<b>171</b>	<b>8%</b>
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>(66)</b>		<b>20</b>		<b>(46)</b>	<b>-8%</b>
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>112</b>	<b>286%</b>	<b>(73)</b>	<b>-186%</b>	<b>39</b>	<b>4%</b>
Дизель түлш	122	136%	(32)	-36%	89	19%
АИ-92, АИ-95	47	291%	(31)	-191%	16	8%
А-80 болон бусад	(57)	86%	(9)	14%	(67)	-28%
<b>Бусад</b>	<b>4</b>		<b>(5)</b>		<b>(1)</b>	<b>-16%</b>
<b>Нийт дүн</b>	<b>159</b>	<b>84%</b>	<b>30</b>	<b>16%</b>	<b>189</b>	<b>4%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 171 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 39 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 27 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 46 сая ам.доллараар буурснаар нийт импорт 189 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан бол өмнөх сараас 2 хувиар өсч тонн тутамд 637 ам.долларт хүрэв.